



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2021/110/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2021 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342315 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Г БУЛГАН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.МӨНХБАТ
ТАНАА

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 96

танай _____-ны № _____ т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д згасны дагуу Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Статистикийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

006020201

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1438000.00</u>	<u>1438000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	1438000.00	1438000.00
354	Хангамжийн материал	1438000.00	1438000.00
35420	Аж ахуйн материал	888000.00	888000.00
35470	Бусад хангамжийн материал	550000.00	550000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8814636.62</u>	<u>41202919.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8814636.62	41202919.52
392	Биет хөрөнгө	8814636.62	41202919.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11666666.79	11666666.79
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9000000.36	-10944444.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28418032.49	47836503.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23611585.46	-9020797.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5970578.50	4779000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4629055.34	-3114007.48
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>10252636.62</u>	<u>42640919.52</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>10252636.62</u>	<u>42640919.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	10252636.62	42640919.52
512	Хуримтлагдсан үр дүн	10252636.62	42640919.52
51210	Өмнөх үеийн үр дүн	15236726.50	10252636.62
51220	Тайлант үеийн үр дүн	-4984089.88	32388282.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>10252636.62</u>	<u>42640919.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	230,719,335.00	359,925,800.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	33,292,824.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	33,292,824.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	26,096,711.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	26,096,711.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	7,196,113.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,719,335.00	326,632,976.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	83,886,600.00	93,313,324.53
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	80,625,600.00	93,313,324.53
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	146,832,735.00	233,319,652.00

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,708,830.00	3,520,120.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,123,905.00	229,799,532.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	235,703,424.88	327,537,517.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,703,424.88	327,537,517.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,403,424.88	326,993,117.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,295,950.00	79,555,931.81
210101	Үндсэн цалин	48,070,600.00	52,355,028.91
210102	Нэмэгдэл	16,203,900.00	15,848,271.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,515,200.00	4,411,164.00
210104	Урамшуулал	-	6,941,467.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,316,500.00	10,412,112.72
210201	Тэтгэврийн даатгал	5,655,200.00	7,282,603.90
210202	Тэтгэмжийн даатгал	665,300.00	818,067.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	532,300.00	644,467.50
210204	Ажилгүйдлийн даатгал	133,100.00	151,906.04
210205	Эрүүл мэндийн даатгал	1,330,600.00	1,515,067.41
2104	Хангамж, бараа материалын зардал	24,385,280.00	22,907,106.00
210401	Бичиг хэрэг	452,900.00	371,980.00
210402	Тээвэр, шатахуун	22,767,100.00	21,607,226.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,400.00	619,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133,600.00	308,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	515,500.00	35,000.00
210604	Урсгал засвар	515,500.00	35,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	128,785,085.00	208,809,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,358,185.00	206,608,066.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,000.00	118,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,100.00	89,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	1,974,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,332,309.88	5,273,541.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544,500.00	369,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,787,809.88	4,904,541.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	544,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	305,000.00

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	305,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	239,400.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	239,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,984,089.88)	32,388,282.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,984,089.88)	32,388,282.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	230719335.00	332879652.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230719335.00	332879652.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	83886600.00	99560000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	80625600.00	99560000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	146832735.00	233319652.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134123905.00	233319652.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	230719335.00	332879652.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230719335.00	332879652.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	230419335.00	326088576.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67295950.00	79555931.81
210101	Үндсэн цалин	48070600.00	52355028.91
210102	Нэмэгдэл	16203900.00	15848271.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2515200.00	4411164.00
210104	Урамшуулал		6941467.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8316500.00	10412112.72
210201	Тэтгэврийн даатгал	5655200.00	7282603.90
210202	Тэтгэмжийн даатгал	665300.00	818067.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	532300.00	644467.50
210204	Ажилгүйдлийн даатгал	166500.00	151906.04
210205	Эрүүл мэндийн даатгал	1297200.00	1515067.41
2104	Хангамж, бараа материалын зардал	2217100.00	2144880.00
210401	Бичиг хэрэг	452900.00	371980.00
210402	Тээвэр, шатахуун	795200.00	845000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835400.00	619400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	133600.00	308500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	515500.00	4035000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4000000.00
210604	Урсгал засвар	515500.00	35000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150756985.00	229571652.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149330085.00	228455252.00
210803	Даатгалын үйлчилгээ	118000.00	118000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89100.00	89100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19800.00	19800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1200000.00	889500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	544500.00	369000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	544500.00	369000.00

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300000.00	6791075.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	300000.00	305000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300000.00	305000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	6486075.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		6486075.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			10,252,636.62		10,252,636.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	10,252,636.62	0.00	10,252,636.62
C08	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	10,252,636.62	0.00	10,252,636.62
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	10,252,636.62	0.00	10,252,636.62
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	10,252,636.62	0.00	10,252,636.62
D08	Тайлант үеийн үр дүн			32,388,282.90		32,388,282.90
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	42,640,919.52	0.00	42,640,919.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	93313324.53	93313324.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	93313324.53	93313324.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	93008324.53	93008324.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	78975931.81	78975931.81
210101	Үндсэн цалин			52355028.91	52355028.91
210102	Нэмэгдэл			15848271.31	15848271.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт			4411164.00	4411164.00
210104	Урамшуулал			6361467.59	6361467.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	10412112.72	10412112.72
210201	Тэтгэврийн даатгал			7282603.90	7282603.90
210202	Тэтгэмжийн даатгал			818067.87	818067.87

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал			644467.50	644467.50
210204	Ажилгүйдлийн даатгал			151906.04	151906.04
210205	Эрүүл мэндийн даатгал			1515067.41	1515067.41
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	2144880.00	2144880.00
210401	Бичиг хэрэг			371980.00	371980.00
210402	Тээвэр, шатахуун			845000.00	845000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			619400.00	619400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			308500.00	308500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00	35000.00	35000.00
210604	Урсгал засвар			35000.00	35000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	1116400.00	1116400.00
210803	Даатгалын үйлчилгээ			118000.00	118000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			89100.00	89100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			19800.00	19800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх			889500.00	889500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	324000.00	324000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			324000.00	324000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	305000.00	305000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	305000.00	305000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			305000.00	305000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	93313324.53	93313324.53
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	93313324.53	93313324.53
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			93313324.53	93313324.53
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага			1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	6.00	6.00
620001	Удирдах ажилтан			1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан			4.00	4.00
620004	Гэрээт ажилтан			1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.0	0.0	6.0	6.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)			5.00	5.00
650010	Гэрээт ажилтан			1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	150093735.00	233080252.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150093735.00	233080252.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150093735.00	233080252.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763650.00	580000.00
210105	Гэрээт ажлын хөлс	506250.00	580000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21971900.00	20762226.00
210402	Тээвэр, шатахуун	21971900.00	20762226.00

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	4000000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл		4000000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127358185.00	207693026.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127358185.00	206608066.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1084960.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	45000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		45000.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	239400.00	0.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		239400.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	150093735.00	233319652.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150093735.00	233319652.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12708830.00	3520120.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134123905.00	229799532.00	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг М.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үр дүнгийн урамшуулал, томилолт, ажил гүйцэтгэх гэрээний баталгаажуулалт дутуу зэрэг зөрчил илэрсэн. Иймд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж дахин давтахгүй байх талаар зөвлөмж, төлбөрийн акт тогтоож менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 18-наас 2021 оны 02 дүгээр сарын 20–ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

“Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино.” гэсэн зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын тушаал
- Холбогдох хууль, тогтоомж, шийдвэрүүд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 320.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 320.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийг хугацаанд нь биелэлтийг хангаж ажиллажээ.

Булган аймгийн Статистикийн хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын 332879.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6657.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25226.8 мянган төгрөгөөр буюу 69 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данснаас машин тоног төхөөрөмжийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1438000.00	1438000.00	0.00
Үндсэн хөрөнгө	46055277.78	64282169.79	-18226892.01
Нийт хөрөнгө	10252636.62	42640919.52	-25226878.98

Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10252636.62	42640919.52	-32388282.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10252636.62	42640919.52	-32388282.90

Бараа материалын дансны үлдэгдэл 1438.0 мянган төгрөг болж 0.0 мянган төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Энэ нь өсөлт, бууралтгүй байгаа нь шаардлагатай бараа материалаар хангагдаж, тооцоо судалгааг үндэслэлтэй төлөвлөж зарцуулсан байна. Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46055.2 мянган төгрөг болж 18226.8 мянган төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмж ҮСХ-оос балансаас баларсны хооронд шилжүүлсэн нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авалтаар 4000.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 7196.1 мянган төгрөгийн дахин үнэлгээний хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталсан 4820.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна. Энэ нь хэрэгцээ шаардлага хангахаа больсон үндсэн хөрөнгийг акталж устгасан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 42640.9 мянган төгрөг болж 32388.2 мянган төгрөгөөр өссөн нь бусад эх үүсвэрээс орж ирсэн буюу дахин үнэлгээ хийсэн үндсэн хөрөнгө шалтгаалжээ. Энэ нь үндсэн хөрөнгийн хүрэлцээг сайжруулсан гэж үзэж байна.

Булган аймгийн Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 129206.5 мянган төгрөгөөр буюу 56 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ҮСХ-оос 26 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авсан байна. Энэ нь балансаас баларсны хооронд шилжиж ирсэн хөрөнгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 91829.1 мянган төгрөгөөр буюу 39 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан акталсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл зардлууд байна. Энэ нь хэрэгцээ шаардлага хангахгүй, ашиглалтын хугацаа дууссан элэгдэл нь дууссан зэрэг шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 119174.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 119174.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 19614.9 мянган төгрөгөөр бууруулж 99560.0 мянган төгрөгөөр баталсан байна. Цар тахлын улмаас нэг удаагийн тэтгэмж, томилолт, урсгал засварын зардлууд хасагдаж төсөв баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 129191.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж Засгийн газраас хүн ам, орон сууцны тооллогыг 10 жилд нэг удаа тоолох тооллогыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3520.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого байхгүй, нийт 99560.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 93313.2 мянган төгрөгийг зарцуулж 6486.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 93313.3 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 6246.6 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн зардлыг 239.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Булган аймгийн Статистикийн хэлтэс нь Улсын болон орон нутгийн төсөвт төсөв төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой 10 жилд нэг удаа болдог Хүн ам, орон сууцны тооллогоор 129191,6 мянган төгрөг нэмэлт санхүүжилтээр батлагдаж ирсэн орлогыг 2020 онд зарцуулж 239.4 мянган төгрөгийг дутуу зарцуулж төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

Төсөвт орсон нэмэлт өөрчлөлт – 5 сар, 11 сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлага - 1 сард хугацаа хоцроосон байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 320.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	320.0	1	320.0	0	0	0
Нийт дүн							

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 414.08 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 414.08 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож аудитын явцад барагдуулсан, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайлан баталгаажуулахад залруулах алдаа зөрчил илрээгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 414.08 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 414.08 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Үр дүнгийн урамшуулал давхардуулж авсан нь “Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дах Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ” гэсэн заалтыг мөрдөж

Шийдвэрлэсэн нь:

2. “Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дах Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайланг баталгаажуулахад үр дүнгийн урамшууллыг давхардуулж авсан, судалгааны ажлаар суманд томилолтоор ажиллахад томилолт хаалгаагүй, судалгааны ажилд ажиллах авто машины гэрээг тухайн гэрээ байгуулж байгаа иргэнээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй зөрчлүүд илэрч байна. Мөн шилэн дансны хуулийн хугацаанд мэдээлээгүй хугацаа хоцроож мэдээлсэн алдаа зөрчил илэрч байна. Санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг заасан хугацаанд биелэлтийг хангаж ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Цаашид санхүүгийн тайлан баталгаажуулах аудит хийж байх хугацаанд хуваарийн дагуу тайлангаа баталгаажуулж байх, шаардсан материал, файлыг шаардсан хугацаанд ирүүлж хүндрэл чирэгдэл үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Томилолтын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Рашаант суманд ажилласан албан томилолт хаагаагүй гарын үсэг дутуу зөрчил илэрлээ.

1.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..”, 13.7 дох “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Ажил гүйцэтгэх гэрээ хэлцэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Ажил гүйцэтгэх авто машин хөлслөх гэрээнд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулах байсан боловч жолооч гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Төсөвт орсон нэмэлт өөрчлөлт – 5 сар, 11 сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого зарлага- 1 сард хугацаа хоцроосон байна.

3.2. Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Булган аймгийн Статистикийн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021 он			БУА-2021/110/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймгийн Статистикийн хэлтэс		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Рашаант суманд ажилласан албан томилолт хаагаагүй гарын үсэг дутуу	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	М.Мөнхбат Ж.Чинчулуун
2	Ажил гүйцэтгэх авто машин хөлслөх гэрээ	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	М.Мөнхбат Ж.Чинчулуун
3	Шилэн данс хугацаа хоцроож мэдээлсэн	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	М.Мөнхбат Ж.Чинчулуун
ДҮН		0			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР